



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/309

Улаанбаатар хот

Цэргийн дүйцүүлэх албаны тусгай үүргийн
бэлтгэл шатны сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг, дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Цэргийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоол, 2024 оны 52 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 74 дүгээр тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/44 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1250 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын 2024-2025 оны сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу цэргийн дүйцүүлэх албаны тусгай үүргийн бэлтгэл шатны сургалтыг 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдрөөс 10 дугаар сарын 05-ны өдрүүдэд зохион байгуулж явуулсугай.

2.Сургалтыг хариуцаж гарах алба хаагчдын нэрийг нэгдүгээр, сургалтад хамрагдах алба хаагчдын нэрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Сургалтыг батлагдсан хөтөлбөр, холбогдох дүрэм, журмын дагуу зохион байгуулж, үр дүнг танилцуулахыг Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб (хурандаа Б.Энхболд)-т үүрэг болгосугай.

4.Цэргийн дүйцүүлэх алба хаагчдын тусгай үүргийн бэлтгэл шатны сургалтад шаардагдах зардлыг Засаг даргын Тамгын газрын батлагдсан төсвийн зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ж.Тамир)-т зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525010947